



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/НЗ

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” А/851, “Зөвлөгөөн зохион байгуулах тухай” А/1393 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын V хуралдаанаар батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартыг хэвлүүлэх ажилд шаардагдах зардлын задаргааг нэгдүгээр хавсралтаар, зөвлөгөөний бэтгэл ажлын зардлын задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хэвлэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хэвлэгдсэн хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, сургалт, арга зүйгээр хангах, хурал зөвлөгөөнд холбогдох удирдамжийн дагуу ашиглаж, зарцуулахыг Хотын хөгжлийн стандартын хэлтэс (Б.Ариунтуяа)-т үүрэг болгосугай.

3.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 166,523,560 (Нэг зуун жаран зургаан сая таван зуун хорин гурван мянга таван зуун жар) төгрөгийг Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас тооцож гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500266